



**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ ДЭРГЭДЭХ
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2022 оны 01 сарын 12 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

Нэр дэвшүүлж, санал болгох тухай

Төрийн албаны тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.6 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн 14 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан "Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам"-ын 7.2 дахь хэсэг, Төрийн албаны зөвлөлийн Эрүүл мэндийн яамны дэргэдэх Салбар зөвлөлийн 2021 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 11 дүгээр тогтоолоор байгуулагдсан Төрийн албаны тусгай шалгалтын Комиссын шийдвэрийг тус тус үндэслэн Төрийн албаны зөвлөлийн Эрүүл мэндийн яамны дэргэдэх салбар зөвлөлийн 2022 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын Санхүү, төсвийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтний албан тушаалд Бат-Очирын Энхцэцэгийг, Эм, эмнэлгийн хэрэгслийн хангамж, хүртээмж, ложистикийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтний албан тушаалд Итгэлийн Баяжаргалыг, Хуулийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтний албан тушаалд Баасанжавын Батбаярыг, Шинэ эм, эмнэлзүйн судалгааны асуудал хариуцсан ахлах мэргэжилтний албан тушаалд Оросоогийн Одончимэгийг, Төсөл, хөтөлбөрийн асуудал хариуцсан мэргэжилтний албан тушаалд Лхачинжавын Мягмардоржийг, Дотоод ажил, удирдлагын зөвлөлийн асуудал хариуцсан мэргэжилтний албан тушаалд Ганхуягийн Ариунбилэгийг, Дотоод аудит, үнэлгээний асуудал хариуцсан мэргэжилтний албан тушаалд Мөнхбатын Энхжаргалыг, Вакцин, биобэлдмэлийн чанар, аюулгүй байдал, зохицуулалтын асуудал хариуцсан мэргэжилтний албан тушаалд Баярбатын Уранбилэгийг, Эмийн зохистой хэрэглээний асуудал хариуцсан мэргэжилтний албан тушаалд Дагвадоржийн Бямбааг, Нянгийн эсрэг эмийн зохистой хэрэглээний асуудал хариуцсан мэргэжилтний албан тушаалд Ганхуягийн Нарангэрэлийг, Шинэ эм, инновацийн асуудал хариуцсан мэргэжилтний албан тушаалд Батбаатарын Хишигжаргалыг, Эмийн экспортын лицензийн асуудал хариуцсан мэргэжилтний албан тушаалд Буянтгогтохын Амарсанааг, Эмийн бүртгэлийн өөрчлөлтийн асуудал хариуцсан мэргэжилтний албан тушаалд Ганзоригийн Бүжмааг, Бүртгэлийн мэдээний сангийн асуудал хариуцсан мэргэжилтний албан тушаалд Эрдэнэ-Очирын Гэрэлт-Эрдэнийг, Эм, эмнэлгийн хэрэгслийн үнэ, худалдан авах ажиллагааны мэдээний сангийн асуудал хариуцсан мэргэжилтний албан тушаалд Шаравнямбуугийн Ариунзаяаг, Нийслэлийн эрүүл мэндийн байгууллагын эмнэлгийн тоног төхөөрөмжийн шалгалт, тохируулгын асуудал хариуцсан мэргэжилтний албан тушаалд Жаргалсайханы Халиунааг, Орон нутгийн эрүүл мэндийн байгууллагын эмнэлгийн тоног төхөөрөмжийн шалгалт, тохируулгын асуудал хариуцсан мэргэжилтний албан тушаалд Батцэцэгийн Санж-Очирыг тус тус томилуулахаар нэр дэвшүүлж, томилох эрх бүхий этгээдэд санал болгосугай.

ДАРГА

Ц.Эрдэмбилэг

Ц.ЭРДЭМБИЛЭГ